



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-НИЙ 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/04/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунжаргал
Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай аудит"
ХХК Захирал Ж.Бямбажав
Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЦС	Дулааны цахилгаан станц
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗХ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ДАШДАВАА ТАНАА

2024.03.15 № 07/746
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь эрчим хүчний алдагдал бууруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрийн нэгжүүдийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний урт хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 124,241.8 сая төгрөг байна. Үүнд: Эрчим хүчний хөтөлбөр-1 төсөл 4,431.0 сая төгрөг, Эрчим хүчний төсөл хөтөлбөр 1,591.4 сая төгрөг, Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл 110,368.2 сая төгрөг, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл 1,278.9 сая төгрөг, Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төсөл 5,278.6 сая төгрөг, Шивээ- овоо нүүрсний уурхайн шинэчлэлийн МОН-Р5 төсөл 980.6 сая төгрөг, УБЦТС ТӨХК –д хэрэгжиж буй Эрчим хүчний дамжуулах үр ашгийг дээшлүүлэх төсөл 313.1 сая төгрөг тус тус байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Эрчим хүчний салбарт хийгдэх томоохон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хамтран ажиллах хариуцлагатай үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл нь 80 МВт суурилагдсан хүчин чадалтай, 200 МВт цагийн багтаамж бүхий Литиум-Ион төрлийн батарей ашигласан

хуримтлуурын байгууламжийг суурилуулж, 220/110/35 кВ-ын "Сонгино" дэд станцад холбох;

- Оюу толгой төсөлд зориулж цахилгаан эрчим хүч худалдан авах, худалдах тухай гэрээний нэмэлт гэрээг БНХАУ-ын Өвөр Монголын Эрчим Хүчний Олон Улсын Хамтын Ажиллагааны компанитай байгуулж, гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг сунгасан;
- Бөөрөлжүүт-Багануур чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын 1-р багцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэснээс гадна Багануур дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 90 хувьтай;
- Чойр-Сайншандын төслийн нэгжийг байгуулж, зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж, 220 кВ-ын Мандалговь-Арвайхээр, 220 кВ-ын Багануур-Чойрын Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэлийг хийж, Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр төлөвлөсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 168 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 164 арга хэмжээ буюу 97.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,791,832,375.92	4,119,213,255.75
1.1.2	Дансны авлага	2,754,809,749.60	1,286,948,641.25
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	14,289,331.80	218,968,759.61
1.1.4	Бусад авлага	193,680,685.81	587,262,975.26
1.1.6	Бараа материал	6,863,981,153.98	7,138,878,871.84
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	77,382,815.09	1,636,268,200.95
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	16,695,976,112.20	14,987,540,704.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	503,251,217,825.01	507,387,015,342.78
1.2.2	Биет бус хөрөнгө	33,980,719,081.91	34,579,189,327.08
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	733,068,164.92	680,706,153.14
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	25,043,148,195.24	115,578,051,734.63
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	563,008,153,267.08	658,224,962,557.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	579,704,129,379.28	673,212,503,262.29
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.5	Богино хугацаат зээл	463,203,094.69	871,339,046.06
2.1.1.6	Хүүгийн өглөг	15,238,923.34	16,691,455.99
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	62,038,210.98
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	505,038,262.75	526,589,607.35
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	983,480,280.78	1,476,658,320.38
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	36,439,948,883.93	123,905,532,133.59
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,747,783,928.79	1,564,299,725.98
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	243,218,727,393.35	255,448,087,753.60
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	281,406,460,206.07	380,917,919,613.17
2.2	Өр төлбөрийн нийт дүн	282,389,940,486.85	382,394,577,933.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,007,137,145.68	45,985,469,154.04
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	33,667,158,220.00	33,667,158,220.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(20,433,174,824.29)	(26,907,770,396.34)
2.3.11	Эздийн өмчийн дүн	297,314,188,892.43	290,817,925,328.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	579,704,129,379.28	673,212,503,262.29

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	71,728,921,851.27	524,591,569,526.84
2	Борлуулалтын өртөг	71,638,864,303.63	531,750,572,711.92
3	Нийт ашиг (алдагдал)	90,057,547.64	(7,159,003,185.08)
4	Түрээсийн орлого	37,427,491.85	31,802,750.09
5	Хүүгийн орлого	-	30,470,249.49
8	Бусад орлого	11,576,306,355.47	14,883,191,923.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	11,851,024,156.76	10,996,250,968.24
11	Санхүүгийн зардал	136,430,245.06	1,873,402,241.52
12	Бусад зардал	2,469,774,321.12	2,952,894,011.95
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,032,839,020.24)	1,400,261,188.45
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		19,775,069.19
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,786,276,348.22)	(6,655,599,364.23)
19	Орлогын татварын зардал	164,111.11	3,921,244.92
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,786,440,459.33)	(6,659,520,609.15)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,786,440,459.33)	(6,659,520,609.15)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	238,073,068,351.04	46,196,475,124.70	27,011,094,880.50	(25,460,301,384.49)	285,820,336,971.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				9,813,567,019.53	9,813,567,019.53
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,196,475,124.70	27,011,094,880.50	(15,646,734,364.96)	295,633,903,991.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,786,440,459.33)	(4,786,440,459.33)
Өмчид гарсан өөрчлөлт			6,656,063,339.50		6,656,063,339.50
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(189,337,979.02)			(189,337,979.02)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	238,073,068,351.04	46,007,137,145.68	33,667,158,220.00	(20,433,174,824.29)	297,314,188,892.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	184,925,037.10	184,925,037.10
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,007,137,145.68	33,667,158,220.00	(20,248,249,787.19)	297,499,113,929.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,659,520,609.15)	(6,659,520,609.15)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(21,667,991.64)			(21,667,991.64)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	238,073,068,351.04	45,985,469,154.04	33,667,158,220.00	(26,907,770,396.34)	290,817,925,328.74

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	127,675,385,094.50	144,573,940,653.44
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	61,902,670,306.66	70,904,544,291.07
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	121,371,319.00	155,906,312.00
	Бусад мөнгөн орлого	65,651,343,468.84	73,513,490,050.37
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	121,678,767,965.27	141,984,629,329.41
	Ажиллагчдад төлсөн	28,302,956,724.54	36,312,908,462.54
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,907,708,639.18	11,614,969,063.04
	Бараа материал худалдан авахад төлсөн	7,338,534,614.20	6,073,272,126.59
	Ашиглалтын зардалд төлсөн	346,330,772.98	402,195,018.19
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,709,951,496.00	2,217,513,591.60
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	95,450,987.38
	Татварын байгууллагад төлсөн	68,655,817,028.06	77,666,383,804.67
	Даатгалын төлбөрт төлсөн	29,889,720.00	55,819,274.44
	Бусад мөнгөн зарлага	6,387,578,970.31	7,546,117,000.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,996,617,129.23	2,589,311,324.03
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	68,146,752.90	85,892,798.03
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	68,146,752.90	55,422,548.54
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	30,470,249.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,517,364,811.09	5,086,244,801.49
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,517,364,811.09	5,079,314,801.49
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	-	6,930,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,449,218,058.19)	(5,000,352,003.46)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,683,076.67	13,056,522.74
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	11,807,869.16
	Бусад	6,683,076.67	1,248,653.58
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	466,322,962.31	274,634,963.48
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	466,322,962.31	271,453,867.51
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Бусад	-	3,181,095.97
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(459,639,885.64)	(261,578,440.74)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,087,759,185.40	2,672,619,120.17)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,704,073,190.52	6,791,832,375.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,791,832,375.92	4,119,213,255.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Харьцуулалт				
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөтэй		Өмнөх оны мөн үетэй		
					Тоо	Хувь	Тоо	Хувь	
Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	7,279.1	7,488.3	7,777.4	289.1	103.9	498.3	106.8	
Дамжуулалтын алдагдал	хувиар	хувь	3.51	3.58	3.55	0.0	99.3	0.0	101.3
	биетээр	сая.кВт.ц	255.1	267.8	276.2	8.4	103.1	21.0	108.2
Дамжуулсан цахилгаан эрчим хүч	сая.кВт.ц	7,024.0	7,220.5	7,501.2	280.8	103.9	477.2	106.8	
Нийт орлого	сая.төг	483,368.7	506,814.2	541,910.8	35,096.6	106.9	58,542.1	112.1	
Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	55,424.9	66,862.4	65,735.8	-1,126.6	98.3	10,311.0	118.6	
Оюутолгой ХХК-тай ЦЭХ, худалдан авах, худалдах гэрээний дагуу тооцсон орлого	сая.төг	416,304.1	425,693.0	458,855.7	33,162.7	107.8	42,551.7	110.2	
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	11,639.8	14,258.7	17,319.2	3,060.5	121.5	5,679.5	148.8	
Нийт зардал	сая.төг	488,155.0	515,240.6	548,566.4	33,325.8	106.5	60,411.5	112.4	
Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	67,322.3	86,209.2	85,764.5	-444.7	99.5	18,442.2	127.4	
Оюутолгой ХХК-тай ЦЭХ, худалдан авах, худалдах гэрээний дагуу тооцсон зардал	сая.төг	416,304.1	425,693.0	458,855.7	33,162.7	107.8	42,551.7	110.2	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	4,528.6	3,338.4	3,946.2	607.8	118.2	-582.5	87.1	
Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	-4,786.3	-8,426.5	-6,655.6	1,770.9	79.0	-1,869.3	139.1	
Орлогын татварын зардал	сая.төг	0.2	0.0	3.9	3.9	0.0	3.8	2,389.4	
Цэвэр ашиг алдагдал	сая.төг	-4,786.4	-8,426.5	-6,659.5	1,767.0	79.0	-1,873.1	139.1	
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.98	0.99	0.0	100.4	0.0	99.8	
Нийт авлага	сая.төг	3,695.8	3,790.5	2,773.9	-1,016.6	73.2	-922.0	75.1	
Үүнээс: ЦЭХ	сая.төг	2,754.8	2,798.4	1,286.9	-1,511.5	46.0	-1,467.9	46.7	
Бусад	сая.төг	941.0	992.1	1,486.9	494.8	149.9	545.9	158.0	
Улсын төсвөөс авах авлага	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Нийт өр төлбөр	сая.төг	282,389.9	313,389.4	382,394.6	69,005.1	122.0	100,004.6	135.4	
Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	983.5	1,699.7	1,476.7	-223.1	86.9	493.2	150.1	
Урт хугацаат өглөг	сая.төг	281,406.5	311,689.7	380,917.9	69,228.2	122.2	99,511.5	135.4	
Банкны зээл	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	сая.төг	10,127.5	13,947.4	9,944.7	-4,002.7	71.3	-182.8	98.2	
Нийт ажилтны тоо	хүн	1,280	1,293	1,286	-7.0	99.5	6.0	100.5	
Цалингийн сан	сая.төг	31,487.1	39,958.3	40,991.9	1,033.6	102.6	9,504.8	130.2	
Нэг ажилтны дундаж цалин	төг	1,953.900	333,729	3,541,726	108.0	103.1	1,587,826	181.3	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зорилгоо “Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль, орчинд ээлтэй, дэвшилтэд технологи ашиглан, цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулах үйлчилгээ үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг:

- Цахилгаан эрчим хүч дамжуулах;
- 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулгын ажил гүйцэтгэх;
- 0.4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах;
- Цахилгаан эрчим хүчний импортлох (БНХАУ-аас);
- Мэргэжлийн сургалт явуулах,
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах зэрэг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах гэж тусгасан байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь 10 хэлтэс, 1 төсөл хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар салбар, Хангайн бүсийн салбар, Төвийн бүсийн салбар, Зүүн өмнөд бүсийн салбар, Говийн бүсийн салбар гэсэн орон нутгийн 5 салбарын хүрээнд 2023 онд 1295 ажилтан албан хаагчтай ажилласан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 66.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34.0 хувийг эзэмшиж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна гэж заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2, Эрчим хүчний яам 4, хараат бус 3 нийт 9 гишүүнтэйгээр томилсон байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК -ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал зардлыг 113.7 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Тус компани нь тайлант онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 137.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 128.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

цалин, урамшууллын зардалд 112.9 сая төгрөг, НДШ-ийн зардалд 15.9 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөгийн зардлыг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн хөрөнгийн нэршлийг компанийн хэмжээнд нэгдсэн нэг нэршилтэй болгох арга хэмжээ авсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хууль
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 289 дүгээр тогтоол “Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний “Холболтын журам”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 67 дугаар “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 725 дугаар тогтоол “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”;
- ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар “Компанийн албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн сүлжээг шинэчлэн өөрчлөх тухай” тогтоол;
- ТУЗ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн “Төлбөртэй ажил, үйлчилгээ гүйцэтгэх журам” 19 дугаар тогтоол.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93,508.4 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,791,832.4	4,119,213.3	(2,672,619.1)
Авлага	2,962,779.8	2,093,180.4	(869,599.4)
Бараа материал	6,863,981.2	7,138,878.9	274,897.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	77,382.8	1,636,268.2	1,558,885.4
Үндсэн хөрөнгө	503,251,217.8	507,387,015.3	4,135,797.5
Биет бус хөрөнгө	33,980,719.1	34,579,189.3	598,470.2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	733,068.2	680,706.2	(52,362.0)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	25,043,148.2	115,578,051.7	90,534,903.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	579,704,129.4	673,212,503.3	93,508,373.9
Богино хугацаат зээл	463,203.1	871,339.0	408,136.0
Хүүгийн өглөг	15,238.9	16,691.5	1,452.5
Урьдчилж орсон орлого	-	62,038.2	62,038.2
Бусад богино хугацаат өр төлбөр	505,038.3	526,589.6	21,551.3
Урт хугацаат зээл	36,439,948.9	123,905,532.1	87,465,583.2
Хойшлогдсон татварын өр	1,747,783.9	1,564,299.7	(183,484.2)
Бусад урт хугацаат өр төлбөр	243,218,727.4	255,448,087.8	12,229,360.4
Өмч: - төрийн	238,073,068.4	238,073,068.4	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	46,007,137.1	45,985,469.2	(21,668.0)
Эздийн өмчийн бусад хэсэг	33,667,158.2	33,667,158.2	-
Хуримтлагдсан ашиг	(20,433,174.8)	(26,907,770.4)	(6,474,595.6)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	579,704,129.4	673,212,503.3	93,508,373.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,119.2 сая төгрөг болж оны эхнээс 2,672.6 сая төгрөгөөр буурсан нь гэрээт ажлын баталгааны болон ажил үйлчилгээний төлбөрийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл оны эцэст 2,093.2 сая төгрөг болж, 29.4 хувиар буурсан байна. Үүнд: Нэмүү өртгийн албан татвар болон бусад авлага 204.7 сая төгрөгөөр өсөж, цахилгааны авлага 1,467.9 сая төгрөгөөр, ААНОАТ-ын авлага 225.5 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдэлд Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан дамжуулалтын үйлчилгээний хөлс /тариф/-с авах 1,286.9 сая төгрөг, харьяа 6, салбараас авах төлбөрт ажил үйлчилгээний нийт 587.2 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 11,957.4 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 11,682.5 сая төгрөгөөр хасагдсан байна. Бараа материалын үлдэгдэлд 6,654.4 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн сэлбэг болон аваарын нөөцийн бараа материал байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд жолоочийн хариуцлагын, тээврийн хэрэгслийн, гэнэтийн ослын даатгалын урьдчилгаа 23.3 сая төгрөг, шатахууны урьдчилгаа 24.5 сая төгрөг, гэрээт ажлын урьдчилгаа тооцоо 16.1 сая төгрөг, агаарын шугамын трас өөрчлөх зардлын урьдчилгаа 1,572.4 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 7, 578, 536, 64 дугаар тогтоолуудаар 24,550.2 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 7,953.8 сая төгрөг, Бүгд Найрамдах Холбооны Герман улсын хандив буюу үнэ төлбөргүй авсан 239.3 сая төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 1/380 дугаар албан бичгийн дагуу балансаас баланст шилжүүлсэн 18.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 653 дугаар тогтоолын дагуу акталсан хөрөнгө 496.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн хүрээнд "Сонгино" батарей хуримтлуурын станцын ажлын 110,605.7 сая төгрөг, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын 2,528.5 сая төгрөг, их засвар болон техникийн зохион байгуулалтын арга хэмжээний дуусаагүй ажлын 2,443.8 сая төгрөг, нийт 115,578.1 сая төгрөгийн дуусаагүй ажлууд бүртгэлтэй байна.

Богино хугацаат зээл дансны үлдэгдэл 871.3 сая болж, 408.2 сая төгрөгөөр өссөн нь урт хугацаат зээлийн тайлант үед ногдох төлбөр болон хүүгийн өглөгтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансанд урьдчилж орсон орлого 62.0 сая төгрөг, салбаруудын урт хугацаат зээлийн тайлант үед ногдох хүү, зээлийн өглөг 877.9 сая төгрөг, гэрээт ажлын 5 хувийн барьцаан төлбөр 526.6 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр болон урт хугацаат зээл дансны үлдэгдэлд төсөл, хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээл 124,776.8 сая төгрөгийн эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл, төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслүүд хэрэгжиж байгаа өр бүртгэлтэй байна. Төсөл, хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээлийн задаргааг Хүснэгт 2-д харуулав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн төсөл, хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээлийн дүн санхүүгийн тайланд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 124,776.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна.

Хүснэгт 2. Урт хугацаат зээлийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Төсөл, арга хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Хөрөнгө оруулагч	Төсөл хэрэгжих хугацаа	Төслийн зорилго
1	Эрчим хүчний хөтөлбөр-1	1,574,279.1	ХБНГУ-ын KFW банкны зээл	33	Эрчим хүчний алдагдал бууруулах
2	Эрчим хүчний хөтөлбөр-1 нэмэлт гэрээ	2,856,707.4	ХБНГУ-ын KFW банкны зээл	28	Эрчим хүчний алдагдал бууруулах
3	Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төсөл	5,278,682.7	Шведийн Свенк Экспорт кредит корпорац	26	Эрчим хүчний алдагдал бууруулах
4	Шивээ- овоо нүүрсний уурхайн шинэчлэлийн МОН-Р5 төсөл	980,638.7	Японы олон улсын хамтын ажиллагааны банк	21	Цахилгааны хэмнэлт
5	Эрчим хүчний төсөл хөтөлбөр	1,591,373.0	Олон улсын хөгжлийн ассоциаци	15	Эрчим хүчний алдагдал бууруулах
6	Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл	110,368,212.3	Азийн хөгжлийн банк	14	Цахилгаан хуримтлуур
7	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл	1,278,994.4	ХБНГУ-ын KFW банкны зээл	15	Дамжуулах үр ашгийг дээшлүүлэх
8	Эрчим хүчний хэмнэлт төсөл	534,933.7	Улаанбаатар дулааны сүлжээ	33	Цахилгаан хэмнэлт төсөл
9	Эрчим хүчний төсөл	313,049.7	УБЦТС ТӨХК	19	Эрчим хүчний дамжуулах үр ашгийг дээшлүүлэх
	Дүн	124,776,871.2			

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 45,985.5 сая төгрөг болж 21.7 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 653 дугаар тогтоолын дагуу 222 нэрийн 497,332.1 сая төгрөгийн анхны өртөгтэй, 476,276.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг акталж, данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан ашиг данс 6,474.5 сая төгрөгөөр төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвдөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, Эрчим хүчний сайдын тушаалаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/26 дугаар тушаалаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 511,674.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 517,503.9 сая төгрөгөөр, алдагдлыг 5,829.4 сая төгрөгөөр баталсан байна. Зорилтот түвшний төлөвлөгөөнд тодотгол хийж Эрчим хүчний сайдын 2023 оны 08 дугаар сарын 16-ний өдрийн А/173 дугаар тушаал, А/224 дугаар тушаалаар 2 удаа тодотгон нийт орлогыг 506,814.2 сая, нийт зардлыг 515,240.6 сая, алдагдлыг 8,426.5 сая төгрөгөөр баталсан байна.

Тус компани нь 7,777.4 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг дамжуулалтад авсан нь төлөвлөснөөс 3.9 хувь буюу 289.1 сая кВт.цагаар, өмнөх оны мөн үеэс 6.8 хувь буюу 498.3 сая кВт.цагаар нэмэгдсэн байна.

Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын дотоод хэрэглээ, техникийн алдагдалд 3.55 хувь буюу 276.2 сая кВт.цаг зарцуулж, төлөвлөгөөнөөс 0.03 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд нийт 541,910.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөнөөс 35,096.6 сая төгрөг буюу 6.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 58,542.1 сая төгрөг буюу 12.1 хувиар өссөн байна.

Орлогын эх үүсвэр нь дамжуулалтын орлого 65,735.8 сая төгрөг, Оюутолгой ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах гэрээний дагуу 458,855.7 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 17,319.2 сая төгрөгийн тус тус орлого бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр нийт зардал 548,566.4 сая төгрөгт хүрч, 6,655.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь байна.

Нийт зардлаас тэтгэмжийн зардал 487.9 сая төгрөг, нийгэм соёлын арга хэмжээний зардал 84.2 сая төгрөг, цахилгааны зардал 20.8 сая төгрөг, дулааны зардал 42.2 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардал 64.1 сая төгрөг, албан томилолтын зардал 79.8 сая төгрөгөөр тус тус дутуу, үндсэн ба нэмэгдэл цалин 1,033.6 сая төгрөг, урсгал засварын зардал 17.9 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардал 9.6 сая төгрөг, санхүүгийн зардал 1,016.6 сая төгрөгөөр тус тус илүү зарцуулжээ. Энэ нь Оюутолгой ХХК-тай хийсэн ЦЭХ-ний худалдах, худалдан авах гэрээ, шатахуун, бараа материалын олдоц ховордсон, урсгал засвар, сэлбэгийн зардлын үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Санхүүгийн зардал хэтэрсэн нь Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур төслийн зээлийн гэрээний заалтын дагуу Сангийн яамтай тооцоо нийлсэн актыг үндэслэн 1,677.5 сая төгрөгийг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 862.7 сая төгрөгийн түлш шатахууны зардал батлагдсанаас 1,795.7 сая төгрөгийн шатахууныг НИК ХХК, Петростар ХХК-аас худалдан авч 933.0 сая төгрөгөөр илүү, 22.5 тонн буюу 155.4 сая төгрөгийн трансформаторын тос батлагдсанаас 16.7 тонн тосыг 165.7 сая төгрөгөөр буюу 10.4 сая төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн байна.

Төлөвлөгөөнд алдагдлыг 8,426.5 сая төгрөгөөр баталсан ба алдагдлын түвшнийг 1,767.0 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар бууруулсан байна.

Тайлант хугацаанд их засварын 290, техник зохион байгуулалтын арга хэмжээний 75, хөрөнгө оруулалтын 62 нийт 427 нэр төрлийн ажлыг 13,957.3 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 411 нэр төрлийн ажлыг 8,984.6 сая төгрөгөөр, өмнөх оны ажлыг 960.1 сая төгрөгөөр, нийт 9,944.7 сая төгрөг зарцуулж, 71.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

СНАГ-2024/4/НА-СТА-ТӨА

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, цалин, зардал, худалдан авалтын талаар холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Дундманхайдай аудит ХХК-ийн ахлах аудитор С.Батжаргал, аудитор Н.Гантөмөр нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Б.Ариунжаргал, аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайлангаа Дундманхайдай аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 01/136 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 488,129.1 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 7,321.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог шинэчлэн, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 25,687.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25,643.6 сая төгрөгийн зарлагын 486 гүйлгээ, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 44.0 сая төгрөгийн 1 ажил буюу нийт 25,687.6 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн б байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны байгуулсан 2023-2024 оны “Хамтын гэрээ”-г Хан-Уул дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөр бүртгэж, хүчин төгөлдөр болсон байна. Хамтын гэрээнд тусгасан зарим заалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай холбогдох заалтуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Хамтын гэрээний 2.4-д компанийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын албан тушаалын үндсэн болон тарифт цалинтай тэмцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгох;
- 2.9-д сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тухайн хамт олон /хэлтэс, алба, хэсэг/-ын албан тушаалын болон тарифт цалингийн 50.0 хүртэл хувиар бодож олгох;
- Сарын болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл олгох журмыг компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан мөрдөх;
- 2.18-д Төрийн захиргааны төв байгууллагаас тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 10,000 төгрөг, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 15,000 төгрөг олгох ба энэ заалт ахмад настан болон тахир дутуугийн группэд байгаа хүмүүст нэгэн адил хамаарах;
- 2.19-д Монгол Улсын төрийн дээд шагнал (Төрийн соёрхолт, Гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар)-аар шагнагдсан салбарын ажилтан, ахмад настанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин хүртэл, “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнагдсан ажилтан, ахмад настанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин хүртэл үржүүлсэнтэй тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшууллыг тус тус олгох;
- 2.20-д Эрчим хүчний яам, салбарын ҮЭ-ийн хорооноос хамтран олгож байгаа “Тэргүүний мастер” цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 100,000 төгрөгөөс доошгүй дагалдах

СНАГ-2024/4/НА-СТА-ТӨА

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

урамшууллыг компанийн Захиргаанаас олгох;

- 4.20-д Төв удирдлага, салбар бүр тэргүүний ажиллагаатай ажилтныг тойрон аяллаар дотоодод, гадаад улсад 10 хоногоос хэтрэхгүй хугацаагаар явуулах, тойрон аяллын нийт зардлын 60.0 хувийг Захиргаа, 40.0 хувийг Үйлдвэрчний эвлэлийн хороо олгох.

Шийдвэрлэсэн нь: Захиргаа үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжид, Төрийн хэмнэлтийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт нь холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага данстад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар нийт 273.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илрүүлж, залруулах зөвлөмж өгч, гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийснийг дахин нягтлан шалгаж, аудитын тайланд залруулгаар тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 24.1 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 14,001.3 сая төгрөгийн 6 албан шаардлага, 1,309.0 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	24,076.1	1	24,076.1	-	-	100.0
Албан шаардлага	6	14,001,326.5	6	14,001,326.5	-	-	100.0
Зөвлөмж	3	1,309,012.9	3	1,309,012.9	-	-	100.0
Нийт дүн	10	15,334,415.5	10	15,334,415.5	-	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөрийн тухай хуульд Эрчим хүчний салбар дундын хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, компанийн хамтын гэрээг харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллага хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, нийцэж байвал тухайн хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг бүртгэхээр заасан ба Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын анхааралд энэхүү асуудлыг уламжлах нь зүйтэй гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 273.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- Спортын арга хэмжээ, ахмадын хүлээн авалт, баярын арга хэмжээнд 5.4 сая төгрөгийн хангамжийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн нь НББОУС2 Бараа материал стандартын 6-д “бараа материал гэдэг нь дараах хөрөнгө юм”, НББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын эргэлтийн хөрөнгө” аж ахуйн нэгж нь дараах тохиолдолд эргэлтийн хөрөнгө гэж ангилна” 66 дугаар заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх” , “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангаагүй ;
- “Компьютерын программ хангамж” дансанд 268.4 сая төгрөгийн газрыг ангилал буруу бүртгэсэн нь НББОУС16 Үндсэн хөрөнгө стандартын 37-д “үндсэн хөрөнгийн анги гэдэг нь аж хауйн нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм, НББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын эргэлтийн хөрөнгө” аж ахуйн нэгж нь дараах тохиолдолд эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна” 67 дугаар заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Ангилал” “Иж бүрэн байх” , “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангаагүй ;

Аудитаар нийт 2,097.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 22.0 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 182.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,892.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,097.1 сая төгрөгийн төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Урьдчилж төлсөн тооцоо дансанд авлагаар бүртгэлтэй Ховд дулааны станцад шилжүүлсэн 9.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг “шатахууны зардал” утгаар үйл ажиллагааны бус зардалд шилжүүлэн бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Эрчим хүчний яамны албан хүсэлтийг үндэслэн тус яамны албан хаагчийн гадаад албан томилолтын зардалд 6.0 сая төгрөг олгосон нь байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолын 2.2-д “төрийн өмчит болон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Тайлан хамгаалалтад зориулан цайны зардалд 6.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.4 хуулиар зөвшөөрөөгүй бусад " гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

4. Төрийн одон медалиар шагнагдсан ажилтан, ахмадуудын урамшуулалд тушаал шийдвэргүй 1.7 сая төгрөг олгосноос татварыг 0.1 төгрөгийн татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.5-д "шууд бус орлого";, 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх";, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Компанийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх хүлээн авалтын зардал 11.2 сая төгрөгийг хувь хүнд шилжүүлсэн нь байх бөгөөд анхан шатны нотлох баримтгүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ,"Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан, компаниас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 36 газрын мэдээлэл зөрүүтэй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д "Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газар эзэмших гэрчилгээ, түүний хавсралт дахь мэдээллийн зөрүүтэй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3. Манчим ХХК-тай Хангайн бүс салбарын ажиллагчдын эрүүл мэндийн үзлэг хийх гэрээний дагуу 25.4 сая төгрөгийг шилжүүлж, үзлэгт хамрагдсаныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагчдыг эрүүл мэндийн үзлэгт гэрээний дагуу хамруулсан эсэх нь тодорхойгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4. Нээлттэй тендер зарлахаас зайлсхийн бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хуваан нийт 145.6 сая төгрөгийн автомашины дугуйг 16 компани, 7 хувь хүнээс шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 8.5-д Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа босго үнийг баримтлахгүй худалдан авалт хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Ажиллагчдын "Орон сууцны нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлэх" зорилгоор олгосон 435.6 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг ажил үйлчилгээний зардалд бүртгэж, татвар ногдох орлогыг бууруулсан байна. Энэ нь Аж ахуйн нэгж орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1."Энэ хуулийн 5.3-т заасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон, түүнчлэн гадаад улсаас олсон орлогод албан татвар ногдоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Татвар ногдох орлогыг бууруулсан зардлыг татвар болон санхүүгийн тайланг залруулах

2.1 Илрүүлэлт:

Уулзалтын үйлчилгээний төлбөрт 7.8 сая төгрөгийг зарцуулсан нотлох дэмжих баримтгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно," гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

2.2 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн бүртэж, тайлагнаж байх

СНАГ-2024/4/НА-СТА-ТӨА



Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Ойн хайгуул ХХК -тай мод тарих, арчлан ургуулах гэрээний дагуу хийсэн 72.3 сая төгрөгийн ажлын мод суулгацыг хөрөнгийн дансанд бүртгээгүй зардалд бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Данс бүртгэлдээ тусгаж, холбогдох байгууллагын шийдвэрээр орон нутгийн өмчлөл рүү шилжүүлэх арга хэмжээ авах.

4.1 Илрүүлэлт:

Говийн болон УБ салбаруудын хөрөнгө оруулалтаар баригдсан дэд станц, газрыг бүртгэх шийдвэр гараагүйгээс данс бүртгэлдээ тусгаагүй байна. Үүнд: МАК-н төслийн хүрээнд баригдсан 220/22/35 кВ-н Цагаан суварга дэд станц, Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны Хүүшийн аманд байрлах 110/35/10 кВ-н "Арцат" дэд станц". Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх

5.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 38.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тогтоол заалттай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс нэмүү өртгийн татвар суутган тооцоогүй, бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын 1,239.8 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжээс И баримтаар худалдан авалтын баримтыг шалган хүлээн авч, данс бүртгэлийг үнэн зөв хөтлөж байх.

Авлагын данстай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Өмнөх онд үүссэн 137.3 сая төгрөгийн цахилгаан дамжуулах шугамын ажлын гүйцэтгэлийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай нийцэхгүй байна.

7.2 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн хөрөнгийн данснаас Спортын арга хэмжээ, ахмадын хүлээн авалт, баярын арга хэмжээнд 5.4 сая төгрөгийн хангамжийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн	1	5.4			1	5.4	1	5.4				
2	"Компьютерын программ хангамж" дансанд 268.4 сая төгрөгийн газрыг ангилал буруу бүртгэсэн байна.	1	268.4			1	268.4	1	268.4				
Дүн		2	273.8			2	273.8	2	273.8				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажиллагчдын "Орон сууцны нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлэх" зорилгоор олгосон буцалтгүй тусламжийг ажил үйлчилгээний зардалд бүртгэж, татвар ногдох орлогыг бууруулсан.	1	435.6					1	435.6				
Ойн хайгуул ХХК -тай мод тарих, арчлан ургуулах гэрээний дагуу хийсэн 72.3 сая төгрөгийн ажлын мод суулгацыг хөрөнгийн дансанд бүртгээгүй зардалд бичсэн байна.	1	72.3					1	72.3				
Говийн болон УБ салбаруудын хөрөнгө оруулалтаар баригдсан дэд станц, газрыг хөрөнгөнд бүртгэх шийдвэр гараагүй ашиглагдаж байна	1	0					1	0				
Үндсэн хөрөнгийн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 38.4 сая төгрөгийн хөрөнгийг	1	0					1	0				

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

цаашид хэрхэн ашиглах талаар шийдвэрлээгүй байна												
Хангайн бүс салбарын ажиллагчдын эрүүл мэндийн үзлэг хийхэд 25.4 сая төгрөг анхан шатны баримтгүй Манчим ХХК-д гэрээний дагуу шилжүүлсэн байна.	1	25.4		1	25.4							
Нээлттэй төндөр зарлахаас зайлсхийж, жижиглэн хувааж нийт 145.6 сая төгрөгийн автомашины дугуйг 16 компани, 7 хувь хүнээс шууд худалдан авалт хийсэн байна.	1	145.6		1	145.6							
Тушаал шийдвэргүй төрийн одон медиалаар шагнагдсан ажилтан, ахмадуудад урамшилд нийт 1.7 сая төгрөгийн мөнгөн аяга өгсний 10 хувийн татвар 0.2 сая төгрөг суутгаагүй байна.	1	0.2	1	0.2								
Уулзалтын үйлчилгээний төлбөрт 7.8 сая төгрөгийг зарцуулсан нотлох дэмжих баримтгүй байна.	1	7.8				1	7.8					
Тайлан хамгаалалтад зориулан цайны зардалд 6.0 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	6.0	1	6.0								
Компанийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх хүлээн авалтын зардал 11.2 сая төгрөгийг хувь хүнд шилжүүлсэн нь нотлох дэмжих баримтгүй байна.	1	11.2			1	11.2						
Эрчим хүчний яамны албан хүсэлтийг үндэслэн ЭХЯ-ны албан хаагчийн гадаад албан томилолгын зардалд 6.0 сая төгрөгийн зардлыг олгосон байна.	1	6.0	1	6.0								
Аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдээс нэмүү өртгийн татвар суутган тооцоогүй, бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын 1,239.8 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй байна.	1	1,239.8				1	1,239.8					
ГЗБ,ГЗЗГ-аас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан, компаниас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 36 газрын мэдээлэл зөрүүтэй байна.	1	0			1	0						
Өмнөх онд үүссэн 137.3 сая төгрөгийн цахилгаан дамжуулах авлагыг барагдуулаагүй байна.	1	137.3				1	137.3					
Урьдчилж төлсөн тооцоо дансанд оны эхний үлдэгдэлтэй Ховд дулааны станцаас авах 9.8 сая төгрөгийн авлагыг "шатахууны зардал" утгаар Үйл ажиллагааны бус бусад зардалд хаасан байна.	1	9.8	1	9.8								
Дүн	15	2,097.1	4	22.0	4	182.3	7	1,892.8	-	-	-	-

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>									
1	Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25,643.6 сая төгрөгийн зарлагын 486 гүйлгээ, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 44.0 сая төгрөгийн 1 ажил буюу нийт 25,687.6 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	25,687.6			1	25,687.6		
Дүн		1	25,687.6			1	25,687.6		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>									
	Компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны байгуулсан 2023-2024 оны "Хамтын гэрээ"-г Хан-Уул дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөр бүртгэж, хүчин төгөлдөр болсон байна. Хамтын гэрээнд тусгасан зарим заалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.	1	0					1	0
Дүн		1	0					1	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 03 дугаар сарын 15

№ 80/А0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/4/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний яамны албан хүсэлтийг үндэслэн тус яамны албан тушаалтны гадаад албан томилолтын 6,006,206.00 /Зургаан сая зургаан мянга хоёр зуун зургаан/ төгрөгийн зардлыг компанийн хөрөнгөөс олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолын 2.2.-д заасан "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрчим хүчний яамны албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд зарцуулсан 6,006,206.00 /Зургаан сая зургаан мянга хоёр зуун зургаан/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹т ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор-Эрдэнэ/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ

¹ Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 15

№ 91/А0150055

Улаанбаатар хот

СХ00Т-2024/4/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлан хамгаалалтад зориулан цайны зардалд 6,000,000.00 /Зургаан сая/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх;" 12 дугаар зүйлийн 12.1. "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлан хамгаалалтын арга хэмжээнд цайны зардал хэмээн зарцуулсан 6,000,000.00 /Зургаан сая/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор-Эрдэнэ/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ.ХХК

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 15

№ 32/00150055

Улаанбаатар хот

Слэдг-2024/4/МА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн одон медалиар шагнагдсан ажилтан, ахмадуудын урамшуулалд тушаал шийдвэргүй 1,755,000.00 /Нэг сая долоон зуун тавин таван мянган/ төгрөг олгосноос 175,500.00 /Нэг зуун далан таван мянга таван зуун/ төгрөгийн татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.5-д "шууд бус орлого"; 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Суутган тооцоогүй татвар 175,500.00 /Нэг зуун далан таван мянга таван зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор-Эрдэнэ/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 15

№ 93/А0150055

Улаанбаатар хот

СМТН-2024/4/НБ-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй Ховд дулааны станцад шилжүүлсэн 9,846,259.28 /Есөн сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун тавин есөн төгрөг хорин найман мөнгөн/ төгрөгийн урьдчилгааг "шатахууны зардал" утгаар үйл ажиллагааны бус бусад зардалд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтууд нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахууны зардал утгаар үйл ажиллагааны бус бусад зардалд тусгасан урьдчилгаа төлбөр 9,846,259.28 /Есөн сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун тавин есөн төгрөг хорин найман мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор- Эрдэнэ/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ, ХХК Ж.БЯМБАЖАВ
ЗАХИРАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15

№ 487/00150055

Улаанбаатар хот

Срелг-2024/4/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25,643,582,967.19 /Хорин таван тэрбум зургаан зуун дөчин гурван сая таван зуун наян хоёр мянга есөн зуун жаран долоон төгрөг арван есөн мөнгө/ төгрөгийн зарлагын 486 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдсан 44,000,000.00 /Дөчин дөрвөн сая/ төгрөг, нийт 25,687,582,967.19 /Хорин таван тэрбум зургаан зуун наян долоон сая таван зуун наян хоёр мянга есөн зуун жаран долоон төгрөг арван есөн мөнгөн/ төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор-Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15

№ 488/20150055

Улаанбаатар хот

Срлрт - 2024/4/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Манчим ХХК-тай Хангайн бүс салбарын ажиллагсдын эрүүл мэндийн үзлэг хийх гэрээний дагуу 25,417,000.00 /Хорин таван сая дөрвөн зуун арван долоон мянган/ төгрөгийг шилжүүлж, үзлэгт хамрагдсаныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилласдын эрүүл мэндийн үзлэгийг гэрээний дагуу хийгдсэнийг нотлох баримтыг бүрдүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор- Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 4189/20150055
СХДТ-2024/4/КА-СТД-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн ерөнхий газраас газрын мэдээллийн лавлагааг авч санхүүгийн тайлан, компаниас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 36 газрын мэдээлэл зөрүүтэй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д "Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй" заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Газар эзэмших гэрээ болон холбогдох хавсралтын мэдээлэл зөрүүтэй дутуу байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлагч бодогч /Э.Болор- Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХИДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 481/20150055
СНАГ-2024/4/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх хүлээн авалтын зардал 11,200,000.00 /Арван нэгэн сая хоёр зуун мянган/ төгрөгийг хувь хүнд шилжүүлсэн байх бөгөөд анхан шатны нотлох баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй" заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөхдөө анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт иргүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор- Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15

№ 490/20150055

Улаанбаатар хот

Слэг - 2024/1/11А - СТА - Т019

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй тендер зарлахаас зайлсхийн бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хуваан нийт 145,682,575.02 /Нэг зуун дөчин таван сая зургаан зуун наян хоёр сая таван зуун далан таван төгрөг хоёр мөнгөн/ төгрөгийн автомашины дугуйг 16 компани, 7 хувь хүнээс шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 8.5.-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй" заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал /Б.Дашдаваа/, Ерөнхий нягтлан бодогч /Э.Болор- Эрдэнэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИГАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс